ARD

ДААТГАЛ

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

MSE: AIC

Улаанбаатар хот, 2021 он

**Агуулга**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг

Хурлаар хэлэлцэх асуудал

1. 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан

2. 2020 онд олгосон ногдол ашгийн тайлан

3. 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт

4. Компанийн хаягийн өөрчлөлтийг дүрэмд тусгах

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийн анкет

Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл

Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Ерөнхий сайд, Амарын гудамж-2,
Ард Холдингс ХК-ийн байр, 2 давхарт
**И-мэйл:** info@arddaatgal.mn **Утас:** 7720 0089

2021 он 03 сар 15 өдөр Дугаар 04/21 Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 65 дугаар зүйлийн 65.1, 71 дүгээр зүйлийн 71.3, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Хувьцаат компанийн хурлын зар хүргэх журмын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 3 сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /цаашид "Хурал" гэх/-ыг 2021 оны 4 сарын 28-ны өдрийн 14 цагт live.ard.mn цахим хаягаар дамжуулан, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2-р давхрын хурлын танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд мэдээлэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг live.ard.mn вэбсайтаар хэрэгжүүлэхээр зохион байгуулсугай.
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийн 2021 оны 3 сарын 31-ний өдрөөр тогтоосугай.
5. Хурлын даргаар Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Ганхуягийг, дараах нэр бүхий хүмүүсийг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр тус тус томилсугай. Үүнд:

   Хурал зохион байгуулах комиссын дарга:
   
   Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах
   
   Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
   
   Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Баярбат
   
   Хуульч Ж.Дамбаасүрэн
   
   Маркетингийн менежер Н.Хандмаа
   
   Мэдээлэл технологийн инженер Н.Бямбасүрэн
   
   Дотоод аудитор П.Бямбасүрэн
   
   Нярав Л.Насанбуян

Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Ерөнхий сайд, Амарын гудамж-2,
Ард Холдингс ХК-ийн байр, 2 давхарт
**И-мэйл:** info@arddaatgal.mn **Утас:** 7720 0089

_______ он _______ сар _______ өдөр Дугаар _______ Улаанбаатар хот

6. Хурлын тооллогын коммиссоор Г.Алтансүх (Блүмсбюри Секьюритис ҮЦК ХХК)-ийг сонгон ажиллуулсугай.
7. Хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар саналаа урьдчилан ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсонд тооцож, саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацааг 2021 оны 4 сарын 28-ны өдрийн 15 цаг 00 минут байхаар тогтоосугай.
8. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Хувьцаат компанийн хурлын зар хүргэх журмын дагуу Хурлын мэдэгдлийг Хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд мэдээлж, Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах боломж, нөхцөлөөр хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Г.Баярбат/-д даалгасугай.

ДАРГА Ч.ГАНХУЯГ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 3 сарын 15-ны
өдрийн 04/21 тоот тогтоолын Хавсралт №1

## 2021 ОНЫ 4 САРЫН 28-НЫ ӨДӨР ХУРАЛДАХ АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ

1. 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. 2020 онд олгосон ногдол ашгийн тайланг танилцуулах тухай;
3. 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
4. Компанийн хаягийн өөрчлөлтийг дүрэмд тусгах тухай;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай;

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 3 сарын 15-ны
өдрийн 04/21 тоот тогтоолын Хавсралт №2

**САНАЛ АВАХ ХУУДАС**
**(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №1)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: ___________________
Регистрийн дугаар:____________________________
Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн
Эзэмшиж буй хувьцааны тоо: ____________________

Энэхүү санал авах хуудсаар 2021 оны 4 сарын 28-ны өдрийн 14 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2 давхрын хурлын танхимд цахимаар хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

| № | Саналын томьёолол | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|---|---|---|---|
| 1. | 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай | | | |

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй бол компанийн байранд ирэх эсвэл www.arddaatgal.mn вэб сайтаас хурлын материалтай танилцаад энэхүү санал авах хуудсаар урьдчилан саналаа өгч болно.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг ____________
Санал авах хуудсыг үйлдсэн 2021 оны ... сарын ... өдөр
Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй
Тооллогын комиссын дарга _______________ (....................)
Хүчингүйд тооцсон бол шалтгаан:
______________________________________________________
______________________________________________________
______________________________________________________
______________________________________________________
______________________________________________________

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 3 сарын 15-ны өдрийн 04/21 тоот тогтоолын Хавсралт №2

## САНАЛ АВАХ ХУУДАС
## (ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №2)

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: __________________
Регистрийн дугаар:___________________________
Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн
Эзэмшиж буй хувьцааны тоо: ____________________

Энэхүү санал авах хуудсаар 2021 оны 4 сарын 28-ны өдрийн 14 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2 давхрын хурлын танхимд цахимаар хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

| № | Саналын томьёолол | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|---|---|---|---|
| 1. | Компанийн хаягийн өөрчлөлтийг дүрэмд тусгах тухай | | | |

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй бол компанийн байранд ирэх эсвэл www.arddaatgal.mn вэб сайтаас хурлын материалтай танилцаад энэхүү санал авах хуудсаар урьдчилан саналаа өгч болно.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг ____________
Санал авах хуудсыг үйлдсэн 2021 оны ... сарын ... өдөр
Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй
Тооллогын комиссын дарга _______________ (....................)
Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

______________________________________________________________
______________________________________________________________
______________________________________________________________
______________________________________________________________
______________________________________________________________

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 3 сарын 15-ны
өдрийн 04/21 тоот тогтоолын Хавсралт №2

**САНАЛ АВАХ ХУУДАС**
**(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №3)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: ___________________
Регистрийн дугаар:____________________________
Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн
Эзэмшиж буй хувьцааны тоо: ____________________

Энэхүү санал авах хуудсаар 2021 оны 4 сарын 28-ны өдрийн 14 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2 давхрын хурлын танхимд цахимаар хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

| № | ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр | Нэр дэвшигчид өгөх саналын тоо |
|---|---|---|
| 1. | ........................................... | ........................................ |
| 2. | ........................................... | ........................................ |
| 3. | ........................................... | ........................................ |
| 4. | ........................................... | ........................................ |
| 5. | ........................................... | ........................................ |
| 6. | ........................................... | ........................................ |
| 7. | ........................................... | ........................................ |
| | ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр | Нэр дэвшигчид өгөх саналын тоо |
| 1. | ........................................... | ........................................ |
| 2. | ........................................... | ........................................ |
| 3. | ........................................... | ........................................ |
| 4. | ........................................... | ........................................ |
| 5. | ........................................... | ........................................ |

Санамж:
1.Кумулятив аргыг хэрэглэхэд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн нэг хувьцаа нь компанийн дүрмээр тогтоосон ТУЗ-ийн нийт гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхтэй байна.
2.Кумулятив аргыг хэрэглэж, сонгогдсон ТУЗ-ийн нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.
3.1.Хувьцаа эзэмшигч та ТУЗ-ийн нийт гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.
Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно.
Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.

Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг ______________/................................/

Санал авах хуудсыг үйлдсэн 2021 оны ...сарын ...-ны өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх:

Тооллогын комиссын дарга _________________/............................../

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

________________________________________________________________________________

________________________________________________________________________________

________________________________________________________________________________

____________________

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 3 сарын 15-ны өдрийн 04/21 тоот тогтоолын Хавсралт №3

**АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 3 сарын 15-ны өдрийн 04/21 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах тухай зарлаж байна.

**Хурал хуралдуулах газар, өдөр, цаг**: 2021 оны 4 сарын 28-ны өдрийн 14 цагт Улаанбаатар хот, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2-р давхрын хурлын танхимд хуралдах, live.ard.mn цахим хаягаар хуралд оролцох боломжтой.

**Компанийн оноосон нэр**: Ард Даатгал ХК

**Хурлын хэлэлцэх асуудал**:
1. 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. 2020 онд олгосон ногдол ашгийн тайланг танилцуулах тухай;
3. 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
4. Компанийн хаягийн өөрчлөлтийг дүрэмд тусгах тухай;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай;

**Бүртгэлийн өдөр**: 2021 оны 3 сарын 31-ний өдөр

**Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:**
1. 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулга;
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудасны загвар;
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
5. 2020 онд олгосон ногдол ашиг хуваарилалтын тайлан;
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл.

Хувьцаа эзэмшигч та 2021 оны 3 сарын 31-ний өдрөөс хойш ажлын өдрүүдэд ажлын цагаар өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандах, эсхүл www.arddaatgal.mn цахим хуудсаар зочлон хурлын материалтай танилцах боломжтой.

**Хаяг:** Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдлийн байр, 2 давхар
**Утас:** 77200088, 88112068

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 3 сарын 15-ны
өдрийн 04/21 тоот тогтоолын Хавсралт №4

**АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ МАТЕРИАЛ**

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулга;
3. 2020 онд олгосон ногдол ашиг хуваарилалтын тайлан;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл.

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн
377 дугаар тогтоолоор баталсан
"Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн
хурлын зар хүргэх журам"-ын нэгдүгээр хавсралт

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ**

| | |
|---|---|
| Компанийн нэр: | Ард Даатгал ХК |
| Хаяг: | Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ард Санхүүгийн Нэгдэл ХК байр, 2 давхарт, live.ard.mn цахим хаягаар |
| Хурал хуралдах өдөр, цаг | 2021 оны 4 дүгээр сарын 28 өдөр<br>14 цаг 00 минут |
| Хурал хуралдах газар /хаяг байршил/: | Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ард Санхүүгийн Нэгдэл ХК байр, 2 давхарт |
| Хурлын төрөл: | Ээлжит |
| Хурал зарлагч: | Төлөөлөн Удирдах Зөвлөл |
| Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо: | 2021 оны 3 сарын 15-ны өдөр |
| Олон нийтэд зарласан огноо: | 2021 оны 3 сарын 16-ны өдөр |
| Бүртгэлийн өдөр: | 2021 оны 3 сарын 31-ний өдөр |
| Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, диллерийн компанид хүргүүлэх огноо: | 2021 оны 3 сарын 22-ны өдөр |
| Хүргүүлсэн огноо: | 2021 оны 3 сарын 16-ны өдөр |
| Хурлын дарга: | ТУЗ-ийн дарга Ч. Ганхуяг |
| Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэрс: | Тооллогын комиссын дарга:<br>Г.Алтансүх<br>Тооллогын комиссын гишүүд: Б.Ариунзул<br>Д.Мөнчанар |
| Баримт бичгийн жагсаалт: | Хавсралтаар |
| Баримт бичгийн хуудасны тоо: | ……. хуудас |

Хурал зохион байгуулах комиссын дарга ……………………… /Г. Цогбадрах/

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

| | |
|---|---|
| - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээх (ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг)<br>  - Хурлын ирц танилцуулах (Тооллогын комисс)<br>  - Хурлын хөтөлбөр, хэлэлцэх асуудал танилцуулах | **14:00-14:20** |
| - Хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу танилцуулга хийх<br>  - 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах; (Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах)<br>  - 2020 онд олгосон ногдол ашгийн тайланг танилцуулах; (Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах)<br>  - 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах; (Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг)<br>  - Компанийн хаягийн өөрчлөлтийг дүрэмд тусгах; (Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах)<br>  - Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох; (Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг) | **14:20-15:20** |
| - Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт | **15:20-15:40** |
| - Санал авах | **15:40-16:00** |
| - Санал хураалтын дүнг нэгтгэн, Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах | **16:00-16:10** |
| - Хурлаас гарсан шийдвэрийг Хурлын дарга танилцуулж, Хурлыг хаах (Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг) | **16:10-16:15** |

Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг 15 минут
Жич: Шаардлагатай тохиолдолд хурлын хугацааг сунгаж болно.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. 2020 онд олгосон ногдол ашгийн тайланг танилцуулах тухай;
3. 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
4. Компанийн хаягийн өөрчлөлтийг дүрэмд тусгах тухай;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай;

## 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2020 оны онцлох үйл явдал

- Ковид-19 цар тахлын хөл хорионы үед ажиллаж байгаа төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, байгууллагуудын ажиллагсдад зориулж даатгалын шинэ бүтээгдэхүүн боловсруулж зах зээлд нэвтрүүлэв.
- Хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэж 2,069 болов.
- Улсын их дэлгүүрт гарсан гал түймрээс үүдэлтэй хохирол, мөн гадаад, дотоодын ачаа тээврийн хохирол зэрэг хэд хэдэн томоохон хохирлуудыг амжилттай нөхөн төлөв.
- Үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлогч гол үзүүлэлт болох ТОП 20 индекст гурван жил дараалан багтаж чадлаа.
- Харилцагчийн менежментийн (CRM) системийг нэвтрүүлэв.
- Монгол Улсад анх удаа "Хүнд өвчний даатгал"-ын шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүллээ
- Ард Санхүүгийн Нэгдэл болон бусад охин компаниудтай хамтран **"Хөрөнгө оруулагч үндэстэн-Хөдөө орон нутагт"** аянг амжилттай хэрэгжүүлж 21 аймагт үйл ажиллагаагаа танилцуулав.
- Их Британи Улсын "The Chartered Insurance Institute"-ээс зохион байгуулсан сургалтад хамрагдав.
- Нийт 5 жил, нээлттэй хувьцаат компани болсноос хойш 3 дахь жилдээ дараалан хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хуваарилав.
- Ард Лайф ХХК-тай хамтран дэлхийн жишигт хүрсэн тэтгэврийн сангийн тогтолцоог нутагшуулах зорилгоор "Гурвалсан тэтгэврийн хуримтлал"-ын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв.
- "Ард койн" урамшуулалт хөтөлбөрийн хүрээнд сүүлийн 3 жил осол гаргаагүй осолгүй, манлай жолооч, даатгуулагчиддаа Ард койн олголоо.
- Цахим даатгалын шийдлийг нэвтрүүлэн, Ард Апп-д даатгалын цэс шинээр нэмэгдэж, апп ашиглагч хэн бүхэн тээврийн хэрэгсэл, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай авах боломжтой боллоо.
- Дэлхийд алдартай телевизийн контент Аппрентис Монголиа бизнесийн шоуг Монгол улсад анх удаа Ард Санхүүгийн Нэгдэл зохион байгуулсан бөгөөд тус шоунд АрдМэнд эрүүл мэндийн даатгалаа танилцуулан амжилттай хамтран ажиллалаа.

## Санхүүгийн байдлын тайлан

| Мянган төгрөгөөр | 2020 оны 12 сарын 31 | 2019 оны 12 сарын 31 |
|---|---|---|
| **Хөрөнгө** | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | **1,176,594** | 422,095 |
| Даатгалын авлага | 2,144,557 | 755,868 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 693,824 | 1,129,819 |
| Бусад санхүүгийн бус хөрөнгө | 921,909 | 611,568 |
| Хөрөнгө оруулалт | **18,009,392** | 15,179,497 |
| Даатгалын хөрөнгө | 3,401,296 | 1,514,608 |
| Үндсэн хөрөнгө (цэвэр) | **2,428,893** | 1,036,618 |
| Биет бус хөрөнгө (цэвэр) | - | 173,590 |
| **Нийт хөрөнгө** | **28,776,465** | **20,823,663** |
| | | |
| **Өр төлбөр ба эздийн өмч** | | |
| **Өр төлбөр** | | |
| Даатгалын өглөг | 3,142,938 | 699,938 |
| Бусад санхүүгийн өр төлбөр | 1,151,113 | 109,278 |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | 372,405 | 329,299 |
| Орлогод тооцоогүй хураамжийн нөөц | 7,690,100 | 4,875,238 |
| Нөхөн төлбөрийн нөөц сан | 3,120,927 | 3,004,901 |
| **Нийт өр төлбөр** | **15,477,483** | **9,018,654** |
| | | |
| **Эздийн өмч** | | |
| Эзэмшигчдийн өмч | 5,000,000 | 5,000,000 |
| Нэмж төлөгдсөн капитал | 3,280,854 | 3,280,854 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | 5,018,128 | 3,524,155 |
| **Эздийн өмчийн дүн** | 13,298,982 | 11,805,009 |
| **Өр төлбөр ба эздийн өмчийн дүн** | **28,776,465** | **20,823,663** |

## Орлого үр дүнгийн тайлан

| Мянган төгрөгөөр | 2020 оны 12 сарын 31 | 2019 оны 12 сарын 31 |
|---|---|---|
| **Даатгалын үйл ажиллагаа** | | |
| Даатгалын хураамжийн нийт орлого | 15,713,525 | 11,409,425 |
| Даатгалын хураамжийн буцаалт | 201,560 | 431,198 |
| Давхар даатгалын хураамжийн зардал | 4,386,090 | 2,082,097 |
| **Даатгалын хураамжийн цэвэр орлого** | **11,125,875** | **8,896,130** |
| | | |
| **Орлогод тооцсон хураамж** | **9,693,703** | **9,623,804** |
| | | |
| Нийт нөхөн төлбөрийн зардал | 4,718,694 | 4,423,371 |
| Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр | 547,323 | 450,787 |
| Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр | 503,943 | 123,843 |
| **Нөхөн төлбөрийн цэвэр зардал** | **3,667,428** | **3,848,741** |
| | | |
| Даатгалын гэрээний зардал | 1,810,430 | 1,953,933 |
| Давхар даатгалын шимтгэлийн орлого | 131,276 | 180,383 |
| Хөрөнгө оруулалтын орлого ба олз | 2,515,906 | 2,410,782 |
| **Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)** | **7,064,167** | **5,824,655** |
| | | |
| Хүү, эрхийн шимтгэлийн орлого | 45,009 | 36,259 |
| Бусад орлого | 197,754 | 213,906 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 1,809,879 | 1,771,322 |
| Борлуулалт, маркетингийн зардал | 2,451,983 | 2,251,051 |
| Санхүүгийн зардал | 22,500 | 3,038 |
| Бусад зардал | 618,014 | 42,716 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | (30,853) | 2,938 |
| Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 837 | (3,066) |
| **Бусад ашиг (алдагдал)** | **(4,689,629)** | **(3,823,966)** |
| | | |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | 2,374,538 | 2,000,689 |
| Орлогын татварын зардал | 226,737 | 281,940 |
| **Татварын дараах ашиг (алдагдал)** | **2,147,801** | **1,718,749** |
| Үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдэл | - | - |
| **Орлогын нийт дүн** | **2,147,801** | **1,718,749** |
| **Нэгж хувьцаанд ногдох ашиг** | 85.91 | 68.75 |

## 2020 ОНД ОЛГОСОН НОГДОЛ АШГИЙН ТАЙЛАН

ТУЗ-ийн 2020 оны 2 сарын 17-ны өдрийн №1/20-2 тоот тогтоолын дагуу компанийн 2019 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчиддээ нэгж хувьцаанд 34 төгрөг буюу цэвэр ашгийн 50 хувь, нийт 850 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн.

Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрөөр буюу 2020 оны 4 сарын 9-ний байдлаар Ард Даатгал ХК-ийн хувьцааг эзэмшиж байгаа нийт хувьцаа эзэмшигчдэд олголоо.

Ногдол ашгийг 2020 оны 5 сарын 20-ны өдөр "Үнэт Цаас Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлсэн байна.

## 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, харилцагч, даатгуулагчид болон хамтран зүтгэгчид та бүхэнд компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулж байна.

2020 онд дэлхий даяар Ковид-19 вирусээс үүдсэн цар тахлын улмаас улсын хил хаагдаж, бүх нийтийн хөл хорио тогтоож, төрөөс онцгой дэглэмд шилжин иргэдийн амьдралын хэв маяг, нийгмийн харилцаа эрс өөрчлөгдсөн, өмнө нь тохиолдож байгаагүй онцгой үйл явдлуудаар дүүрэн жил боллоо. Төр засгаас иргэд, аж ахуй нэгжүүдийнхээ аюулгүй байдлыг хангах, орлогын эх үүсвэрийг тасалдуулахгүй байх тал дээр анхаарч ажилласан хэдий ч ард иргэдийн, бизнесийн байгууллагуудын хувьд ч онцгой хүнд нөхцөл байдалд ажил, амьдралаа залгуулан ажиллалаа. Цар тахлын улмаас олон компани үүд хаалгаа барьж, ажилчдаа цомхотгон бүтээгдэхүүн, үйлчилгээгээ зогсоох нөхцөл байдалд хүрсэн харамсалтай үр дагавар нийтлэг байв.

Харин Ард Даатгал ХК-ийн хувьд хураамжийн орлого, хөрөнгө оруулалтын орлого, цэвэр ашиг, нөөц сан, нийт хөрөнгө, эздийн өмч зэрэг санхүүгийн үзүүлэлтүүдээрээ хамгийн өндөр хэмжээнд хүрч өнгөрсөн жилийн нийтлэг хандлагыг сөрөн зах зээл дээрх байр сууриа нэмэгдүүлсэн, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлсэн, ололт амжилтаар дүүрэн он жил боллоо. Манай компанийн хувьцаа эзэмшигчид цар тахлын онцгой нөхцөл байдалтай уялдан хурлаа анх удаа цахимаар амжилттай зохион байгуулсан. Ард Даатгал ХК-ийн хувьцаа 1.2 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, оны эцэст 800 төгрөгөөр хаагдаж, 2020 онд хувьцаа эзэмшигчдийн тоо 432 хувьцаа эзэмшигчээр нэмэгдэн 2,069 болж Ковид-19 цар тахлын улмаас бизнесийн үйл ажиллагаа тасалдах эрсдэлтэй тодорхойгүй хүнд үед Ард Даатгал ХК нь 850 сая төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчиддээ олгосон нь бага ч гэсэн хувь нэмэр оруулсан гэж найдаж байна. Хүчтэй. Хамтдаа

ТУЗ нь улирал бүр компанийн дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлж буй арга хэмжээ, төлөвлөгөөт ажлуудын үр дүнг хэлэлцэж, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг чиглүүлэх, санал, шүүмжлэл хэлж, засаж залруулж ирсэн. 2020 онд хураамжийн орлого 15.7 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын орлого 2.5 тэрбум төгрөгт тус тус хүрсэн бол нийт 4.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосны 547.3 сая төгрөгийг давхар даатгалаас төлүүлсэн байна. Ард Даатгал ХК нь мөн онд 2.1 тэрбум төгрөгийн цэвэр ашиг олж хувьцаа эзэмшигчдийнхээ итгэлийг алдалгүй ажиллаа. ТУЗ-ийн 2021 оны эхний хурлаар цэвэр ашгийн 48.15 хувиар буюу 1.0 тэрбум төгрөгийн мөнгөн хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 40 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэж, 2021 оны 7 сарын 30-ны дотор хувьцаа эзэмшигчиддээ олгохоор боллоо.

2021 онд даатгалын үндсэн системийг цахим шилжилтэд бэлтгэх, хөрвүүлэх бусад систем, аппликэйшнтэй холбох, иргэдийн даатгал, нөхөн төлбөрийн үйл ажиллагааг цахимжуулах зэрэг цоо шинэ боломжуудыг зах зээлд бий болгон ажиллах үүргийг гүйцэтгэх удирдлагад даалган хариуцууллаа. Мөн аймгийн төвүүд, алслагдсан сум, суурин, хөдөө орон нутагт даатгалын үйлчилгээг иж бүрнээр хүргэхэд Ард Даатгалын 100 гаруй ажиллагсдаас гадна Монгол Шуудангийн салбарууд, Ард Санхүүгийн Нэгдлийн орон нутаг дахь төлөөлөгчид даатгалын борлуулалтыг хийхэд тууштай дэмжин ажиллана.

ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлсэн ажлын үр дүнд сэтгэл хангалуун байгаа ба компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлд хангалттай гэсэн дүгнэлтийг хийж, компанийн Гүйцэтгэх захиралд бүрэн итгэл хүлээлгэн ирээдүйд тавьсан зорилго, зорилтууддаа хүрэхэд ТУЗ-ийн зүгээс бүх талаар дэмжин ажиллах болно.

**КОМПАНИЙН ХАЯГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ ДҮРЭМД ТУСГАХ ТУХАЙ;**

Компанийн төв оффисын хаягт өөрчлөлт орж байгаатай холбогдуулан Ард Даатгал ХК-ийн дүрмийн 1.5-д "Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байр, 2 давхарт, утас: 7720 0088, www.arddaatgal.mn, info@arddaatgal.mn" гэж тусгасныг "Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр, 13 давхарт, 1305 тоот утас: 7720 0088, www.arddaatgal.mn, info@arddaatgal.mn" гэж өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигч:



Чулуун **Ганхуяг**
Төрсөн он сар: 1973.11
Иргэншил: Монгол

| **Сургуулийн нэр** | **Байршил** | **Элссэн он** | **Төгссөн он** | **Эзэмшсэн мэргэжил** |
|---|---|---|---|---|
| Корвинус Эдийн Засгийн Их Сургууль | Унгар, Будапешт | 1993 | 1997 | Эдийн засагч |

| **Байгууллагын нэр** | **Албан тушаал** | **Ажилласан хугацаа** |
|---|---|---|
| Ард Санхүүгийн Нэгдэл ХК | Гүйцэтгэх захирал | 2014-одоог хүртэл |
| Ард Даатгал ХК | ТУЗ-ийн дарга | 2013-одоог хүртэл |
| Ард Кредит ББСБ ХК | ТУЗ-ийн дарга | 2013-одоог хүртэл |
| И Ай Ти ХХК | ТУЗ-ийн дарга | 2012-2014 |
| Монгол Улсын Сангийн Яам | Дэд сайд | 2010-2012 |
| Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК | Гүйцэтгэх захирал | 2003-2010 |
| ХасБанк | Гүйцэтгэх захирал | 2002-2009 |
| Х.А.С ББСБ | Гүйцэтгэх захирал | 1999-2001 |
| Монгол Банк | Хянан шалгагч | 1997-1998 |
| Монголын Хөрөнгийн Бирж | Хянан шалгагч, орчуулагч | 1991-1992 |



Одончимэд **Одбаяр**
Төрсөн он сар: 1966.8
Иргэншил: Монгол

| Сургуулийн нэр | Байршил | Элссэн он | Төгссөн он | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|---|
| Отгонтэнгэр Их Сургууль | Монгол, Улаанбаатар | 1997 | 2000 | Эрх зүйч |
| Техникийн Их Сургууль | АНУ, Флорида | 1996 | 1997 | Олон улсын эдийн засагч |
| Багшийн Их Сургууль | Украйн, Киев | 1984 | 1988 | Багш |

| Байгууллагын нэр | Албан тушаал | Ажилласан хугацаа |
|---|---|---|
| Ард Санхүүгийн Нэгдэл ХК | ТУЗ-ийн гишүүн | 2014-одоог хүртэл |
| Ард Даатгал ХК | ТУЗ-ийн гишүүн | 2015-одоог хүртэл |
| Ард Кредит ББСБ ХК | ТУЗ-ийн гишүүн | 2015-одоог хүртэл |
| Эрдэнэс Монгол ХХК | Бизнес хөгжил эрхэлсэн дэд захирал | 2016-? |
| Эрдэнэс Стийл ХХК, Шивээ Овоо ХК | ТУЗ-ийн дарга | 2016-? |
| Чингис Хаан Зочид Буудал Цогцолбор ХХК | Гүйцэтгэх захирал | 2012-2015 |
| Алтай Холдинг ХХК | Дэд ерөнхийлөгч | 2012-2015 |
| Монгол Улсын Засгийн Газар | Монгол Улсын Ерөнхий Сайдын зөвлөх | 2010-2012 |
| Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ | Атташе, Гуравдугаар нарийн бичгийн дарга | 2005-2010 |
| МИАТ ХК | Бээжин дэх төлөөлөгч | 2002-2004 |
| Монгол-Хятадын хамтарсан Си Эм Эйч төрийн өмчит компани | Монгол талын Гүйцэтгэх захирал | 2000-2002 |
| Монгол Улсын Их Сургууль | Багш | 1988-1992 |



Галбадрах **Цогбадрах**
Төрсөн он сар: 1975.2
Иргэншил: Монгол

| Сургуулийн нэр | Байршил | Элссэн он | Төгссөн он | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|---|
| АНУ-ын Үндэсний Их Сургууль | АНУ, Лос Анжелес | 2009 | 2010 | Бизнесийн удирдлагын магистр |
| Монгол Улсын Их Сургууль | Монгол, Улаанбаатар | 1993 | 1997 | Санхүүгийн менежмент, банкны эдийн засгийн бакалавр |

| Байгууллагын нэр | Албан тушаал | Ажилласан хугацаа |
|---|---|---|
| Ард Даатгал ХК | Гүйцэтгэх захирал | 2017-одоог хүртэл |
| Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Ард Секюритиз ҮЦК, Ард Менежмент ҮЦК | ТУЗ-ийн гишүүн | 2015-2017 |
| Тэнгэр Даатгал ХХК | Гүйцэтгэх захирал | 2011-2014 |
| ХасБанк | Дотоод аудит, салбарын удирдлага, Санхүү бүртгэл, Хөрөнгө зохицуулалтын газрын захирал | 2000-2008 |
| Голомт банк | Гадаад төлбөр тооцооны нябо | 1996-1997 |



Батбилэг **Золбоо**
Төрсөн он сар: 1996.1
Иргэншил: Монгол

| **Сургуулийн нэр** | **Байршил** | **Элссэн он** | **Төгссөн он** | **Эзэмшсэн мэргэжил** |
|---|---|---|---|---|
| Платсбург Коллеж | АНУ, Нью Йорк | 2013 | 2016 | Санхүү, нягтлан бодох бүртгэл |
| СЭЗИС | Монгол, Улаанбаатар | 2012 | 2013 | Олон улсын мэргэшсэн нягтлан бодогч |

| **Байгууллагын нэр** | **Албан тушаал** | **Ажилласан хугацаа** |
|---|---|---|
| Ард Санхүүгийн Нэгдэл ХК | Санхүү эрхэлсэн захирал | 2018-одоог хүртэл |
| Ард Менежмент ҮЦК ХХК | Гүйцэтгэх захирал | 2017-2018 |
| Ард Секюритиз ҮЦК ХХК | Хөрөнгө оруулалтын шинжээч | 2016-2017 |



Чулуун **Ганзориг**
Төрсөн он сар: 1986.11
Иргэншил: Монгол

| Сургуулийн нэр | Байршил | Элссэн он | Төгссөн он | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|---|
| Корвинус Эдийн Засгийн Их Сургууль | Унгар, Будапешт | 2007 | 2010 | Бизнес менежментийн бакалавр |

| Байгууллагын нэр | Албан тушаал | Ажилласан хугацаа |
|---|---|---|
| Ард Экс ХХК | Гүйцэтгэх захирал | 2020-одоог хүртэл |
| Ард Кредит ББСБ ХК | Гүйцэтгэх захирал | 2013-2019 |
| Ард Даатгал ХК | ТУЗ-ийн гишүүн | 2018-одоог хүртэл |
| Ард Санхүүгийн Нэгдэл ХК | Санхүү эрхэлсэн захирал | 2017-2018 |
| Ард Санхүүгийн Нэгдэл ХК | Хөрөнгө оруулалтын шинжээч | 2012-2013 |
| Ард Секюритиз ҮЦК ХХК | Хөрөнгө оруулалтын шинжээч | 2010-2012 |



Сүхдорж **Оргил**
Төрсөн он сар: 1980.6
Иргэншил: Монгол

| **Сургуулийн нэр** | **Байршил** | **Элссэн он** | **Төгссөн он** | **Эзэмшсэн мэргэжил** |
|---|---|---|---|---|
| Сиднейн технологийн их сургууль | Австрали, Сидней | 2002 | 2006 | Програм хангамжийн инженер |
| Колорадогийн их сургууль | АНУ, Колорадо | 1998 | 2000 | Ерөнхий |

| **Байгууллагын нэр** | **Албан тушаал** | **Ажилласан хугацаа** |
|---|---|---|
| ПостКэйр ХХК | Гүйцэтгэх захирал | 2014-одоог хүртэл |
| Мост ПСП ХХК | Захирал | 2012-одоог хүртэл |
| Мост ПСП ХХК | Ерөнхий захирал | 2009-2012 |
| Гаалийн Ерөнхий Газар | МХТ/Худалдан авалт хариуцсан мэргэжилтэн | 2007-2009 |
| Мост Өртөө ХХК | Гүйцэтгэх захирал | 2006-одоог хүртэл |

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД



Зоригт **Ариун**
Төрсөн он сар: 1988.8
Иргэншил: Монгол

| **Сургуулийн нэр** | **Байршил** | **Элссэн он** | **Төгссөн он** | **Эзэмшсэн мэргэжил** |
|---|---|---|---|---|
| INSEAD | Сингапур | 2013 | 2014 | Бизнесийн удирдлагын магистр |
| Valparaiso University | АНУ, Индиана | 2006 | 2010 | Бизнесийн удирдлага болон банк санхүүгийн бакалавр |

| **Байгууллагын нэр** | **Албан тушаал** | **Ажилласан хугацаа** |
|---|---|---|
| Улаанбаатар хот дахь Америк сургууль | Зөвлөх багш | 2016-одоог хүртэл |
| Insignia XXK | Үүсгэн байгуулагч, захирал | 2012-одоог хүртэл |
| Одод XXK | Бизнес хариуцсан менежер | 2012-2013 |
| Улаанбаатар хот дахь Америк сургууль | Бизнес хариуцсан менежер | 2010-2012 |



Баатарзоригт **Болорчимэг**
Төрсөн он сар: 1991.4
Иргэншил: Монгол

| Сургуулийн нэр | Байршил | Элссэн он | Төгссөн он | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|---|
| Хүмүүнлэгийн ухааны их сургууль | Монгол, Улаанбаатар | 2015 | 2016 | Бизнесийн удирдлагын магистр |
| Хэвлэлийн хүрээлэн | Монгол, Улаанбаатар | 2011 | 2012 | Сэтгүүлч |

| Байгууллагын нэр | Албан тушаал | Ажилласан хугацаа |
|---|---|---|
| Өрөг.мн | Үүсгэн байгуулагч, Ерөнхий продюсер | 2019-одоог хүртэл |
| NTV ТВ | Сэтгүүлч, Хөтлөгч | 2016-2019 |
| МЛС Трэйнинг ХХК | Сургагч багш | 2013-одоог хүртэл |
| Шинэ дэлхий ТВ | Сэтгүүлч, Хөтлөгч | 2012-2014 |



Ичинхорлоо **Сэр-Од**
Төрсөн он сар: 1976.8
Иргэншил: Монгол

| **Сургуулийн нэр** | **Байршил** | **Элссэн он** | **Төгссөн он** | **Эзэмшсэн мэргэжил** |
|---|---|---|---|---|
| Монгол Улсын Их Сургууль | Монгол, Улаанбаатар | 1995 | 1998 | Хуульч |
| Орхон коллеж | Монгол | 1993 | 1995 | Референт |

| **Байгууллагын нэр** | **Албан тушаал** | **Ажилласан хугацаа** |
|---|---|---|
| Монголын бизнесийн зөвлөл | Дэд захирал | 2008-2014 |
| МҮХАҮТ | Гадаад харилцааны газрын дарга, мэргэжилтэн | 2002-2007 |
| УИХ-ын Тамгын газар | Зохион байгуулагч | 1999-2001 |



Батаа **Чойжил**
Төрсөн он сар: 1983.4
Иргэншил: Монгол

| Сургуулийн нэр | Байршил | Элссэн он | Төгссөн он | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|---|
| Төв Куинслэндийн их сургууль | Австрали | 2019 | 2021 | Бизнесийн удирдлагын магистр |
| Удирдлагын академи | Монгол, Улаанбаатар | 2015 | 2016 | Төрийн удирдлага |
| Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль | Монгол, Улаанбаатар | 2001 | 2005 | Нягтлан бодогч |

| Байгууллагын нэр | Албан тушаал | Ажилласан хугацаа |
|---|---|---|
| Эрдэнэс менежмент ассетс ХХК | Гүйцэтгэх захирал | 2019-2019 |
| Эрдэнэс Монгол ХХК | Газрын захирал | 2013-2019 |
| ХасБанк | Мэргэжилтэн, салбарын захирал | 2006-2013 |
| Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар | Санхүүгийн улсын байцаагч | 2005-2006 |

төсөл

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 он 4 сар 28 өдөр | №1/21 | Улаанбаатар хот

2020 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 2021 оны 4 сарын 28-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын ... тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсралтаар батлсугай.

ХУРЛЫН ДАРГА Ч.ГАНХУЯГ

төсөл

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 он 4 сар 28 өдөр №02/21 Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 2019 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссынн ..... тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр ............ овогтой ............-ыг, хараат бус гишүүнээр ............. овогтой.................-ыг тус тус сонгохыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн мэдээллийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж, зохих зөвшөөрлийг авч ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Г.Баярбат)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Ч.ГАНХУЯГ

төсөл

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 он 4 сар 28 өдөр №03/21 Улаанбаатар хот

Дүрмийн өөрчлөлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 2021 оны 4 сарын сарын 28-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын ... тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн дүрмийн 1.5-д "Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар 14200, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1305 тоот" гэж өөрчлөн, өөрчлөлтийг компанийн дүрэмд тусгахыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, дүрмийн өөрчлөлтийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх, Санхүүгийн Зохицуулах Хороонд мэдээлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Цогбадрах)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Ч.ГАНХУЯГ

2020

Хүчтэй. Хамтдаа.